

Нийтийн биеийн
тамирын арга
хэмжээний зурагт
мэдээ

Соёл, спорт, аялал жуулчлалын газрын харъяа усан спорт, сургалтын төвд байдбилдингийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий танхимын нээлтийг 2014 оны 01 сарын 16-нд хийлээ.



“Өвлийн агаар-Өлчир бие” сэдэвт өдөрлөгийг 2014 оны 01 сарын 18-нд Хаялага дээр зохион байгууллаа. Өдөрлөгийн арга хэмжээг спортын 5 төрлөөр зохион байгуулж, нийт 19 байгууллагын 350 гаруй албан хаагч, ажилчид оролцлоо.



Хөдөөгийн залуучуудын дунд “Хөдөөгийн баясгалан” өдөрлөгийг 08 сарын 16-нд зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр волейбол, олс таталт, хөгжилтэй буухиа, хэвтээ шахалт, цагираг эргүүлэх зэрэг тэмцээнүүдийг зохиож эхний 3 байр болон нийлбэр дүнгээр байр эзлүүлсэн.



Усан спорт сонирхогч, хичээллэгчдийн дунд “Усаар чийрэгжье” сэдэвт аюул өдөрлөг 08-р сарын 09-нд зохион байгуулагдсан. Мэлхий сэлэлтийн аймгийн анхдугаар тэмцээн эрэгтэй 150м, эмэгтэй 100м, хүүхэд 50м-ийн мэлхий сэлэлтийн тэмцээн зохион байгуулагдсан.



Монгол улсын засгийн 05 тогтоол, Засгийн газрын 34-р тогтоол буюу “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Ажлын байранд хийх дасгал, хийн дасгал”-ын тэмцээнийг зохион байгуулж 6-н байгууллага, 2 ахмадын хороо оролцсон.



Соёл, спорт, аялал жуулчлалын газар “Хос мөнгөн хурд” дугуйн холбоотой хамтран “Эрүүл амралт-6” дугуйн аялал 2014 оны 08 сарын 16-17 ны өдрүүдэд Чойр хот- Зараагийн зүүн өврийн хүн чулуу-Сансар уул гэсэн маршрутаар зохион байгуулагдаж 71 км аялалаа. Аялагчид Зараагийн зүүн өврийн хүн чулуу-Сансар уул үзэн түүх дурсгалтай танилцлаа. Спортын 2 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, нийт 28 иргэд оролцсон.



Улс орнуудыг найрамдал нөхөрлөл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах зорилготой Энх тайвны галт бамбарт гүйлт энд онд таван тивийн 140 гаруй улс орны нутаг дэвсгэрээр буухиалж, 49 гаруй мянган километр замыг туулан явж байна.

Манай орон нутгийг дамжин өнгөрөх даян дэлхийн Энх тайвны галт бамбарт гүйлтийн үндсэн багийг гүйгчид аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж өөрийн аймагт буухиалан гүйх багийг бүрдүүлэн хүлээн авч, дамжин өнгөрүүлээ.



“Спортын бага наадам”-ыг 03 сарын 7-16-ны хооронд амжилттай зохион байгуулж Тэмцээнд 69 байгууллага нэгдэн 30 багийн 800 гаруй албан хаагч, ажилчид оролцож спортын 5 төрлөөр зохион байгуулсан. Политехник коллеж 3-р байр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 2-р байр, Чойр Цахилгаан түгээх сүлжээ 1-р байрыг эзлэн аваргын цом, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.





Улаанбаатар хотын хүй долоон хутагт 09 сарын 12-14-ны өдрүүдэд Үндэсний спортын 5-р их наадамд аймгаас спортын 6 төрлөөр амжилттай оролцсон. Үндэсний бөхийн төрөлд 6-р байранд, сур харвааны төрөлд багийн дүнгээр 8-р байр, цуваа харваанд Политехник коллежийн багш Ж.Норжмаа спортын мастер, Усан спортын сургалтын төвийн багш Б.Батмөнх спортын дэд мастерын болзол хангасан.



“Эх байгалиа хайрлаж идэвхтэй амьдарцгаая” сэдэвт явган аялалын өдөрлөгийг Сүмбэр-Цагаан дарь эх-Хаялга-Сүмбэр гэсэн аялалын ойрын маршрутаар хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн дунд зохион байгуулав.Өдөрлөгийг АЗДТГ, ЭМГ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд 12 багийн 128 иргэн оролцсон байна.



Спортын тэмцээн уралдааны зурагт МЭДЭЭ

Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ын үеэр







014 оны 03 сарын 02-нд ССАЖГ-ын спорт зааланд Аймгийн аварга шалгаруулах өсвөрийн шатрын тэмцээн амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн. Тэмцээнд 5 сургуулийн 70 гаруй хүүхэд, багачууд оролцлоо.



Дэлхийн Зөн ОУБ-ын бор-Өндөр 1 орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Политехникийн коллежийн нэрэмжит өсвөрийн үеийн жүдо бөхийн олон хотын нээлттэй тэмцээнийг 2014 оны 05 сарын 12, 13-ны өрүүдэд амжилттай зохион байгуулсан. Нийт тэмцээнд 8 шилдэг багийн 180 гаруй хүүхдүүд оролцож Говьсүмбэр Политехникийн коллежийн дэргэдэх “Чойрын бүргэд” клубын баг тамирчид 2-р байранд орсон.





Говьсүмбэр аймгийн Жахрай мэргэн сурын холбооны "Нээлт-2014" харваа 2014 оны 05 сарын 04-ний өдөр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.



Аймгийн өсвөрийн хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээнийг 2014 оны 05 сарын 10-нд хонхорын хөнгөн атлетикийн талбайд амжилттай зохион байгууллаа. Тэмцээн нь гүйлт-100м, 200м, 400м, 800м, 1500м, Уртын харайлт, бөөрөнцөг шидэлт гэсэн төрлүүдээр амжилттай явагдаж өндөрлөсөн. Багийн нэгдсэн дүнгээр 1-р байранд Д.Пүрэвням багштай 5-р сургуулийн баг тамирчид, 2-р байранд Д.Нарантуяа багштай Шивээговь сумын 3-р сургуулийн баг тамирчид, 3-р байранд О.Батбаяр багштай 2-р сургуулийн баг тамирчид орсон.



Улаанбаатар хотын хүй долоон хутагт 09 сарын 12-14-ны өдрүүдэд Үндэсний спортын 5-р их наадамд аймгаас спортын 6 төрлөөр амжилттай оролцсон. Үндэсний бөхийн төрөлд 6-р байранд, сур харвааны төрөлд багийн дүнгээр 8-р байр, цуваа харваанд Политехник коллежийн багш Ж.Норжмаа спортын мастер, Усан спортын сургалтын төвийн багш Б.Батмөнх спортын дэд мастерын болзол хангасан.



2014 оны 04 дүгээр сар 07-09-ний өдрүүдэд Жудо бөхийн өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан. Тэмцээнд эрэгтэй 14, эмэгтэй 10 жингийн ангиллаар зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгуудын 216 өсвөр үеийн тамирчид оролцож амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд эмэгтэй жингээр 1-р байранд Говьсүмбэр аймгийн "Чойрын бүргэд" клуб, 2-р байранд Хэнтий аймгийн баг тамирчид, 3-р байранд Дорнод аймгийн баг тамирчид, эрэгтэй жингээр 1-р байранд Дорнод аймгийн баг тамирчид, 2-р байранд Хэнтий аймгийн баг тамирчид, 3-р байранд Дорноговь аймгийн баг тамирчид орлоо.



Сагсан бөмбөгийн спортын мастер У.Мөнхбаатарын нэрэмжит нээлттэй тэмцээн 2014 оны 10 сарын 24-25-ны өдрүүдэд Соёл, спорт, аялал жуулчлалын газрын зааланд ажллттай зохион байгуулж 23

багийн 170 гаруй шилдэг сагсчид оролцож ур чадвараа сорин өрсөлдлөө. 1-р байранд цахилгаан дамжуулах сүлжээний баг тамирчид, 2-р байранд Төмөр замын гал унтраах ангийн баг тамирчид, 3-р байранд ансот багийн тамирчид орлоо. Шилдэг тоглогчоор Ч.Зоригтбаатар шалгарлаа.



Улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан баг тамирчид





Олон улсын тэмцээнээс медаль авсан баг, тамирчид

Чөлөөт бөхийн Азийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээний эрэгтэйчүүдийн 120 кг-ын жинд Энхтөрийн Мөнхбаатар амжилттай барилдаж хүрэл медаль хүртлээ.



АНУ-д болсон 2014 оны Жюү Жицү бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд О.Жавхланбаяр дасгалжуулагчтай Политехник коллежийн дэргэдэх “Чойрын бүргэд” клубын тамирчид 2 мөнгөн медаль хүртлээ.

Эрэгтэйчүүдийн 58 кг-ын жинд Ш.Бумбаяр, эмэгтэйчүүдийн +69 кг-ын жинд Н.Уранхишиг нар мөнгөн медаль хүртсэн.



2014 онд Волейболын монгол туурагтаны хүүхдийн их наадмаас Т.Халиунсайхан, С.Бүдсүрэн, Х.Соёлмаа нар оролцож мөнгөн медаль хүртсэн байна.

Нэрэмжит тэмцээн болон бусад тэмцээнээс медаль баг тамирчид

04 сарын 13-18 хооронд Улаанбаатар хотноо болсон боксын спортын мастер П.Ядамсүрэнгийн нэрэмжит залуучуудын олон хотын боксын аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцлоо. Тэмцээний эрэгтэй +69 кг-д оролцсон тамирчин н.Ундралболд хүрэл, эмэгтэй +60 кг-д тамирчин Б.Цэндсүрэн мөнгө медаль авсан.

2014 оны 10 сарын 4-6 –ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт Үндэсний бөхийн өсвөр, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах Тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож 17 насны ангилалд Б.Бямбадорж 13-р байранд, 18-ны ангилалд Ц.Нямсүрэн 12-р байранд орсон.

Монгол улсын эмэгтэйчүүдийн жүдог үндэслэгч, жүдо, самбо бөхийн анхны шигшээ багийн дасгалжуулагч, Монгол улсын Гавъяат дасгалжуулагч Ч.Машбатын нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээн нь 10 сарын 13-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Спортын төв ордон “А” зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 32 гаруй байгууллагын 657 гаруй баг тамирчид оролцлоо. Говьсүмбэр аймгаас 25 өсвөрийн тамирчин оролцож 66 кг жинд Ч.Уугарбаяр хүрэл медаль хүртсэн.



2014 оны 10-р сарын 13-22 хооронд Улаанбаатар хотын Буян-тухаа спортын ордонд болох Идэрчүүдийн шилдэг 8-н багийн аврага шалгаруулах Волейболын “СУПЕР-8” тэмцээнд амжилттай оролцож байна.